

МӨНГӨНИЙ ТОЙМ

2017 оны 7 дугаар сар

- Мөнгөний нийлүүлэлт 7 дугаар сард 3.8%-иар өсч 14.0 их наяд төгрөг болов.
- Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт өмнөх сард буурч 20.5% байсан бол тайлант сард 23.3% болов.
- Мөнгөний нийлүүлэлтийн сарын өсөлтийн дийлэнх хэсгийг валютын харилцах, хадгаламж бүрдүүлэв.
- Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө болон банкуудын Төв банк дахь харилцах буурснаар нөөц мөнгө буурч 3.0 их наяд төгрөг болов.
- Нийт хадгаламжийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл тайлант сард өсч нийт дүн нь 13.0 их наяд төгрөгт хүрэв. Үүний 51.4 хувь нь хувийн хэвшилд, 47.5 хувь нь иргэдэд олгосон зээл байна.
- Хадгаламжийн байгууллагуудын нийт зээлийн 6.8 хувь нь хугацаа хэтэрсэн, 8.8 хувь нь чанаргүй зээл байна.

МӨНГӨ, САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2016				2017			
	12-р сар	1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	7-р сар
Инфляци								
Улаанбаатар хотын	сарын 0.7	0.9	0.6	1.6	1.5	0.6	-0.6	-0.1
оны эхнээс	0.5	0.9	1.6	3.2	4.8	5.4	4.8	4.7
жилийн	0.5	1.7	1.8	3.0	3.2	3.8	3.5	3.3
Суурь	сарын 0.3	0.1	0.1	0.7	1.2	0.5	0.1	0.0
оны эхнээс	0.5	0.1	0.2	0.9	2.1	2.7	2.7	2.7
жилийн	0.5	-0.1	2.1	2.8	3.9	4.5	4.7	4.0
Улсын	сарын 0.6	1.0	0.8	1.2	1.2	0.5	-0.6	0.1
оны эхнээс	1.1	1.0	1.8	3.0	4.2	4.7	4.1	4.2
жилийн	1.1	2.1	2.4	3.1	3.3	3.7	3.3	3.4
Мөнгө, санхүүгийн сектор								
Нөөц мөнгө, сая ₮	3,064,435.9	2,712,102.5	2,675,173.0	2,749,861.6	2,779,941.0	2,984,657.4	3,179,512.5	3,000,564.2
сарын өөрчлөлт, хувиар	-5.7	-11.5	-1.4	2.8	1.1	7.4	6.5	-5.6
жилийн өөрчлөлт, хувиар	24.6	17.5	15.9	17.0	-7.0	-6.9	-9.8	-7.1
M2 мөнгө, сая ₮	12,158,585.7	11,973,868.9	12,339,426.1	12,260,193.1	12,468,774.0	12,990,617.7	13,484,132.8	13,999,629.6
сарын өөрчлөлт, хувиар	3.7	-1.5	3.1	-0.6	1.7	4.2	3.8	3.8
жилийн өөрчлөлт, хувиар	21.0	21.6	23.3	21.2	18.6	21.9	20.5	23.8
Бусад хадгаламж, сая ₮	10,010,810.5	9,960,422.3	10,153,603.4	10,134,430.0	10,154,583.5	10,501,971.5	10,763,504.3	11,415,447.5
сарын өөрчлөлт, хувиар	2.2	-0.5	1.9	-0.2	0.2	3.4	2.5	6.1
жилийн өөрчлөлт, хувиар	19.7	20.9	19.6	18.8	15.0	17.8	16.9	21.9
Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө, сая ₮	823,629.3	736,068.2	944,705.5	788,251.9	834,150.2	875,421.5	914,953.8	887,573.6
сарын өөрчлөлт, хувиар	7.1	-10.6	28.3	-16.6	5.8	4.9	4.5	-3.0
жилийн өөрчлөлт, хувиар	16.6	3.1	44.1	19.7	12.0	11.0	9.0	8.5
Хадгаламжийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл, сая ₮	12,422,719.9	12,379,975.2	12,584,005.0	12,678,515.4	12,707,157.3	12,711,501.8	12,903,057.4	13,038,365.9
сарын өөрчлөлт, хувиар	-2.3	-0.3	1.6	0.8	0.2	0.0	1.5	1.0
жилийн өөрчлөлт, хувиар	6.1	5.0	8.1	7.1	9.2	11.0	7.3	7.7
Хад. байгууллагуудын чанаргүй зээлийн үлдэгдэл, сая ₮	1,051,680.5	1,056,150.4	1,070,100.6	1,035,475.9	1,087,258.3	1,158,298.4	1,132,293.2	1,149,719.5
сарын өөрчлөлт, хувиар	-9.9	0.4	1.3	-3.2	5.0	6.5	-2.2	1.5
жилийн өөрчлөлт, хувиар	20.9	18.1	17.5	7.0	1.3	9.0	9.3	11.7
Мөнгөний үржүүлэгч	4.0	4.4	4.6	4.5	4.5	4.4	4.2	4.7
Банк хоорондын зах								
Илүүдэл нөөц, сая төгрөгөөр	-24.0	-62.9	-36.5	-58.7	-23.8	-32.3	-73.5	-67.2
сарын өөрчлөлт, хувиар	50.3	-162.3	42.1	-60.9	59.4	-35.6	-127.5	8.6
Илүүдэл нөөц - Байнгын санхүүжилт	-5,955.0	-39,316.6	5,823.3	-24,819.1	-12,738.5	3,342.2	-28,842.1	24,707.1
сарын өөрчлөлт, хувиар	81.4	-560.2	114.8	-526.2	48.7	126.2	-963.0	185.7
Илүүдэл нөөц - ТБ-ны буцах санхүүжилт + ОН + ТБҮЦ	530,470.2	329,615.4	510,237.6	895,349.6	1,166,964.2	1,288,816.8	1,604,933.3	1,591,622.3
сарын өөрчлөлт, хувиар	-40.0	-37.9	54.8	75.5	30.3	10.4	24.5	-0.8
Хүү (хувиар)								
Хадгаламжийн ЖДХ	13.1	13.4	13.3	13.0	13.0	12.8	12.1	12.8
Хадгаламжийн бодит хүү*	12.6	11.7	11.5	10.0	9.7	9.0	8.6	9.4
Зээлийн ЖДХ**	19.7	20.2	20.1	20.2	20.0	20.4	20.3	20.1
Зээлийн бодит хүү*	19.2	18.4	18.3	17.2	16.8	16.5	16.8	16.7
Ипотекийн зээлийн хүү	10.3	9.6	10.3	10.3	10.5	10.3	10.2	10.1
ТБҮЦ-ны ЖДХ	14.5	14.0	14.0	14.0	14.0	14.0	12.9	12.0
Бодлогын хүү	14.0	14.0	14.0	14.0	14.0	14.0	12.0	12.0
БХЗ-ын ЖДХ	15.5	14.5	14.9	15.0	15.0	14.7	13.1	12.3

* Улаанбаатар хотын хэрэглээний барааны үнийн индексээр тооцсон

** Төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү

Мөнгөний нийлүүлэлт

М2 мөнгөний нийлүүлэлтийн 51.7%-ийг төгрөгийн хадгаламж бүрдүүлж байгаа бол 18.1%-ийг валютын хадгаламж, 14.0%-ийг төгрөгийн харилцах бүрдүүлж байна.

М2 мөнгөний жилийн өсөлт 2017 оны 6 дугаар сард 20.5% байсан бол 7 дугаар сарын эцэст 23.3% боллоо. Жилийн өсөлтийн дийлэнх хувийг төгрөгийн хадгаламж бүрдүүлсэн хэвээр байна.

Өмнөх сараас М2 мөнгөний нийлүүлэлт 3.8% (516.3 тэрбум төгрөгөөр)-иар өсч 14.0 их наяд төгрөгт хүрэв. Үүнд бусад хадгаламж, харилцах 6.1% (651.9 тэрбум)-иар өсч, М1 мөнгө 5.0% (136.0 тэрбум)-иар буурсан нь нөлөөлөв.


Бусад хадгаламж, харилцахын бүрэлдэхүүн хэсгүүдээс валютын харилцах 334.9 тэрбум төгрөгөөр, валютын хадгаламж 209.0 тэрбум төгрөгөөр, төгрөгийн хадгаламж 108.1 тэрбум төгрөгөөр тус тус өсчээ.

М1 мөнгөний бүрэлдэхүүн хэсгээс төгрөгийн харилцах 96.8 тэрбум төгрөгөөр, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 38.8 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.


Зураг 1. М2 жилийн өсөлтийн задаргаа (эх үүсвэрээр)



Зураг 2. М2 сарын өсөлтийн задаргаа (эх үүсвэрээр)




Зураг 3. М2 сарын өөрчлөлт, тэрбум ₮



Нийт хадгаламжийн 62.7%-ийг иргэдийн хадгаламж бүрдүүлж байна. Харин гадаад валютын хадгаламжийн нийт хадгаламжид эзлэх хувь 25.9%-д хүрч өмнөх сараас өсчээ.

Тайлант сард иргэдийн гадаад валютын хадгаламж өмнөх сараас 7.9%-иар, байгууллагын валютын хадгаламж 12.9%-иар өсчээ. Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн өөрчлөлтийн нөлөөг хасч тооцвол нийт гадаад валютын хадгаламж өмнөх сараас ойролцоогоор 4.8%-иар өссөн байна.

Зураг 4. Хадгаламжийн үлдэгдэл (иргэд, байгууллага)



Гадаад, дотоод актив


M2 мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас нь авч үзвэл хадгаламжийн байгууллагуудын дотоод цэвэр актив өмнөх сараас 305.1 тэрбум төгрөгөөр, гадаад цэвэр актив 211.3 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Гадаад цэвэр активын өөрчлөлтөд бусад хадгаламжийн байгууллагуудын гадаад цэвэр актив 198.0 тэрбум төгрөгөөр өссөн нь голчлон нөлөөлөв.


Дотоод цэвэр авлага өмнөх сараас 30.0 тэрбум төгрөгөөр өсч 18.3 их наяд төгрөг болжээ. Үүнээс Засгийн газраас авах цэвэр авлага 133.1 тэрбум төгрөгөөр буурсан бол улсын байгууллагаас авах авлага 20.1 тэрбум төгрөгөөр, хувийн хэвшлээс авах авлага 65.2 тэрбум төгрөгөөр, иргэдээс авах авлага 66.5 тэрбум төгрөгөөр тус тус өсчээ.

Тайлант сард нөөц мөнгө 178.9 тэрбум төгрөгөөр буурч 3.0 их наяд төгрөг болжээ. Банкуудын Төв банк дахь харилцах 151.6 тэрбум төгрөгөөр, хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгө 38.8 тэрбум төгрөгөөр буурсан бол банкуудын касс дахь мөнгө 11.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Зураг 5. Хадгаламжийн байгууллагуудын гадаад, дотоод цэвэр актив



Зураг 6. Нөөц мөнгө



Хадгаламжийн байгууллагын зээлийн үлдэгдэл


Хадгаламжийн байгууллагуудаас олгосон зээлийн үлдэгдэл өмнөх сараас 135.3 тэрбум төгрөгөөр өсч 13.0 их наяд төгрөг болжээ.

Нийт зээлийн үлдэгдлийн 51.4 хувийг хувийн хэвшилд, 47.5 хувийг иргэдэд, 1.1 хувийг бусад салбарт олгосон зээл бүрдүүлж байна.


Нийт зээлийн үлдэгдэлд хугацаа хэтэрсэн зээлийн эзлэх хувь өмнөх сараас бага зэрэг өсч 6.8 хувьд хүрсэн бол чанаргүй зээлийн хувь өмнөх сарын түвшинд буюу 8.8 хувьд байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн 81.6 хувь, чанаргүй зээлийн 80.2 хувь нь хувийн хэвшилд олгосон зээл байна.

Зураг 7. Хадгаламжийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл, жилийн өсөлт



Зураг 8. Хадгаламжийн байгууллагын хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээл



Мөнгөний зах

Тухайн сард банкууд банк хоорондын захаар дамжуулан 266.3 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн байна. Үүний 67.1 хувийг овернайт зээл, 18.7 хувийг Төв банкны үнэт цаасны арилжаа, 1.4 хувийг банк хоорондын хадгаламж, 4.3 хувийг репо арилжаа, тус тус бүрдүүлжээ.

Банкууд 2017 оны 7 дугаар сарын 5-ны өдрөөс 8 дугаар сарын 1-ний өдрийн хооронд заавал байлгах нөөцийн шаардлага хангах, төлбөр тооцоо, гүйлгээний зорилгоор 2455.4 тэрбум төгрөгийг Монголбанк дахь төгрөгийн харилцахад, 1654.6 тэрбум төгрөгтэй тэнцэх валютыг валютын харилцах дансанд тус тус байршуулжээ.

Зураг 9. Банк хоорондын захын арилжааны дүн, хүү




ХҮҮ

Тайлант сард олгосон болон үлдэгдэлд жигнэсэн төгрөгийн зээлийн хүү өмнөх сараас бага зэрэг буурч харгалзан 20.1%, 18.2% болсон бол жилийн өмнөх түвшинтэй харьцуулбал 0.9 болон 0.3 нэгж хувиар өссөн байна.


Харин тайлант сард олгосон валютын зээлийн хүү өмнөх сарынхаас 0.8 нэгж хувиар, жилийн өмнөхөөс 1.4 нэгж хувиар буурч 11.7%-д хүрсэн бол үлдэгдлээр жигнэсэн валютын зээлийн хүү өмнөх сарын болон жилийн түвшинд буюу 11.6%-тай байна.

Тайлант сард төгрөгийн хадгаламжийн үлдэгдлээр жигнэсэн дундаж хүү өмнөх сараас 0.1 нэгж хувиар, жилийн өмнөхөөс 0.4 нэгж хувиар буурч 12.8% болов. Тухайн сард татсан хадгаламжийн хүү 0.1 нэгж хувиар өсч 12.6%-д хүрчээ. Гадаад валютын хадгаламжийн хүү бага зэрэг буурч 5.5%-д хүрсэн бол тухайн сард татсан валютын хадгаламжийнх 1.0 нэгж хувиар өсч 5.3% болжээ.

Зураг 10. Зээлийн жигнэсэн дундаж хүү



Зураг 11. Хадгаламжийн жигнэсэн дундаж хүү




Валютын ханш

2017 оны 7 дугаар сарын эцэст Монголбанкнаас зарласан төгрөгийн ам.доллартай харьцах ханш 4.0 хувь буюу 95.1 төгрөгөөр суларч 2445.0 болжээ. Тухайн сард төгрөгийн ам.доллартай харьцах дундаж ханш 2409.4 төгрөг байв. 2017 оны 5 дугаар сарын эцэст төгрөгийн евротой харьцах ханш 2867.2, Хятадын юаньтай харьцах ханш 363.3, ОХУ-ын рубльтай харьцах ханш 40.6 байв.

Тайлант сард төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханшийн индекс 4.0%-иар буурсан буюу төгрөгийн гадаад валюттай харьцах ханш энэ хэмжээгээр сулрав.

Зураг 12. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн индекс, 2010.12.31 = 100




Инфляци

Зураг 13. Улаанбаатар хотын сарын инфляци

2017 оны 7 дугаар сарын инфляци УБ хотын хэмжээнд -0.1 хувь буюу өмнөх сараас бага зэрэг буурав. Хүнсний барааны үнэ мөн -0.1 хувиар буурснаас хүнсний ногооны үнэ 13.3 хувиар, бусад хүнс 0.3 хувиар өссөн бол сүү 0.5 хувиар, мах 1.3 хувиар буурсан байна.

Харин хүнснээс бусад бараа, үйлчилгээ өмнөх сарынхтай ижил түвшинд байна.



Зураг 14. Улаанбаатар хотын жилийн инфляци

Жилийн инфляци УБ хотын хэмжээнд 2017 оны 7 дугаар сарын байдлаар 3.3 хувь байгаагийн 2.8 нэгж хувийг хүнснээс бусад бараа, үйлчилгээ, 0.5 нэгж хувийг хүнсний бараа, бүтээгдэхүүн бүрдүүлсэн байна.

Хүнсний бүлгийн үнэ жилийн 2 хувийн өсөлттэй байгаагаас сүүний үнэ 12.7 хувиар өсч, хүнсний ногоо 10.7 хувиар, мах 1.6 хувиар буурчээ. Харин хүнснээс бусад бараа үйлчилгээний бүлгийн үнэ жилийн 3.8 хувийн өсөлттэй байгаагаас тээвэр 11 хувиар, орон сууц, ус, цахилгааны үнэ 2.5 хувиар, хувцас, гуталны бүлгийн үнэ 0.3 хувиар өсчээ.

